

**МОНГОЛ УЛСЫН 2018-2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХӨТӨЛБӨРТ ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

	Арга хэмжээ	Суурь үзүүлэлт 2018 оны түвшин	Шалгуур үзүүлэлт 2019	Төсөвт өртөг, Эх үүсвэр, Суурь үзүүлэлт 2017 он /сая төг/	Гүйцэтг эл 2018	Санхүүжилт	Хэрэгжил- тийн хувь
1. ШИЛЖИН ХЭРЭГЖИХ ТӨСЛҮҮД							
Зам, тээврийн хөгжлийн сайд							
1	Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудал төслийн нэмэлт санхүүжилт	Төслийн ажлын явц 80 хувь.	Төслийн ажлын явц 90 хувь. Барилгын ажлыг бүрэн дуусгаж, үйл ажиллагааг 2019 оны 7 дугаар сард багтаан эхлүүлнэ.	Гадаад зээл, тусламж /Японы хөнгөлөлттэй зээл/ Нийт 741,186.0	2018 он 41,363.8	2019 он 87,902.3 Санхүүжсэн 2019 он 140,467.6	100%
		Нийт 13 чиглэлийн барилга байгууламжийг дуусгасан. Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгын ажлын гүйцэтгэл 25.8%, ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний барилгын ажил 85.9%, нисэх буудлын аэродромын засвар үйлчилгээний барилгын ажил 87.8%-ийн гүйцэтгэлтэй байна.		2017 оны суурь үзүүлэлт 527,175.0		Санхүүжилтийн хувь 100	
				Улсын төсөв Нийт 122,874.2 2017 он 58,310.5	2018 он 7,117.8	2019 он - Санхүүжсэн 2019 он 226,100.0 Санхүүжилтийн хувь 100	
2018 он: Монгол Улсын Засгийн газар болон Японы Олон улсын хамтын ажиллагааны банк хооронд 2008.05.01-ны өдөр 28,8 тэрбум иенийн үнийн дүнтэй MON-P8 “Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төслийн зээлийн үндсэн гэрээ”, 2015.04.16-ны өдөр 36,8 тэрбум иенийн үнийн дүнтэй MON-P12 “Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх онгоцны буудал барих төслийн зээлийн нэмэлт гэрээ”-г тус тус байгуулсан.							

		<p>“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл”-н үндсэн гэрээний хүрээнд баригдсан нийт 13 чиглэлийн барилга байгууламжид улсын комисс ажиллаж, 2018.09.03-ний өдрийн 07/02/18 тоот актаар баталгаажуулсан. Хэрэгжилт 100%</p> <p>ЗГ-ын 2017.08.17-ны өдрийн хуралдааны 36 дугаар тэмдэглэлд Ангарын барилга, агаарын хөлгийн явгалах зам, зогсоол, дэд бүтцийн шугам сүлжээ, газар шорооны ажил болон зураг төслийг шинэ нисэх буудал барих зээлийн үлдэгдэл хөрөнгөөр санхүүжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлэхийг ЗТХЯ, СЯ-нд даалгасан. Уг тэмдэглэлд үндэслэн шинэ нисэх буудлын зээлийн гэрээний үлдэгдэл /ойролцоогоор/ 4,4 тэрбум иенийн хөрөнгөөр ангарын барилга байгууламжийг цогцоор нь гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн. Агаарын хөлгийн засвар үйлчилгээний барилгын ажлын гүйцэтгэл 2018.11.01-ний өдрийн байдлаар 25.8%-тай байна.</p> <p>Монгол Улсын төсвийн санхүүжилтээр баригдаж буй 3 барилгын:</p> <ul style="list-style-type: none"> - Захиргааны барилгыг ашиглалтад оруулах улсын комисс ажиллаж, ашиглалтад хүлээн авсан. 100% - Ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний барилгын ажил – 85.9% - Нисэх буудлын аэродромын засвар үйлчилгээний барилгын ажил – 87.8% <p>Нийт төслийн ажил 80%-тай.</p> <p>Олон улсын шинэ нисэх буудлын үйл ажиллагааг 2019 оны 07 дугаар сард багтаан эхлүүлэхээр ажиллаж байна.</p> <p>2019 он:</p> <ul style="list-style-type: none"> -Ачаа, шуудан, тээврийн үйлчилгээний барилга, - Нисэх буудлын үйлчилгээний барилга-д Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019.12.19-ний өдрийн 381 дүгээр тушаалаар томилогдсон улсын комисс 2019.12.23-ны өдөр ажиллаж, барилга байгууламжийг үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад авсан. - Төслийн нэмэлт зээл /MONP-12/-ийн хүрээнд баригдсан “Агаарын хөлгийн засвар үйлчилгээний цогцолбор барилга, байгууламж баригдаж дууссан. ИНЕГ-аас техникийн комисс ажиллаж дүгнэлт гаргасан. Улсын комисс ажиллуулах хүсэлт ирүүлээд байна. 					
2	Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл	<p>Төслийн ажлын явц 12 хувь.</p> <p>Төсөл хэлэлцээрийн шатандаа явж байгаа бөгөөд хэрэгжиж эхлээгүй байна.</p>	<p>Төслийн ажлын явц 15 хувь.</p> <p>Нисэх буудлын үйл ажиллагаанд бэлтгэх ажил үргэлжилнэ.</p>	Хөрөнгө оруулах-ашиглах-шилжүүлэх Нийт 43,399.8	-	<p>2019 он 43,399.8 Санхүүжсэн 17,748.9</p> <p>Санхүүжилтийн хувь 100</p>	100%
		<p>2018 он: ЕС-ын 2016 оны 63 дугаар захирамжаар байгуулагдсан “УБ хотын ОУНОШБ-ын менежмент төсөл”-ийг санал тавьсан этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсэг, Японы консорциумтай концессын гэрээний хэлэлцээг 2017.01.30-ны өдөр эхлүүлсэн. Ажлын хэсэг дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:</p>					

	<p>Ажлын хэсэг Японы Консорциумын төлөөлөлтэй удаа дараа уулзалт зохион байгуулж, гэрээний хэлэлцээний дараагийн шатанд хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, талууд хэлэлцээрийг түргэвчлэх талаар анхаарч, хамтран ажиллах тухай харилцан тохиролцсон.</p> <p>Монгол болон Японы талууд гэрээний хэлэлцээг саадгүй явуулахын тулд харилцан тохиролцоо шаардлагатай асуудлуудыг хэлэлцэж эхлэлтийн хөрөнгө оруулалтын тооцоо судалгааг боловсруулсан. Төслийн саналын техникийн болон санхүүгийн үнэлгээг нэгтгэн дүгнэж, шаардлага хангасан гэж үзсэн тухайгаа Мицубиши корпорацид албан бичгээр хүргүүлсэн;</p> <p>Японы Консорциумын хүсэлтээр Ажлын хэсэг “Хүннү эйр” ХХК болон “Аэромонголиа” ХХК-ийн удирдлагуудтай 2017.02.23-ны өдөр шинэ нисэх буудалд шилжин ажиллах бэлтгэл ажлын талаар хэлэлцсэн. Японы Консорциумын хамтаар дотоодын агаарын тээвэрлэгчидтэй шинэ нисэх буудалд шилжин ажиллах бэлтгэл ажлын талаар 2017.03.28-29-ний өдрүүдэд уулзалт зохион байгуулж, тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцэв.</p> <p>Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэхэд тулгамдаж буй асуудлууд болон шинэ нисэх буудлын үйл ажиллагааг Японы Консорциумтай хамтран хэрэгжүүлснээр үүсч болох эрсдэлүүд зэрэг асуудлуудыг тусгасан ажлын хэсгийн тайланг 2017.04.29-ний өдөр Ерөнхий сайдад танилцуулсан.</p> <p>Японы Консорциум Монголын тал болон Японы талын эзэмших хувь хэмжээг нарийвчлан тооцоолсон нэмэлт хувилбаруудыг боловсруулсан.</p> <p>Японы Консорциум дэх Мицубиши Корпорацийн санхүү хөрөнгө оруулалт хариуцсан төлөөлөгч, ИНЕГ болон ЗТХЯ-ны төлөөлөлтэй 2017.09.04-08-ны өдрүүдэд ажиллаж, МУ зээлийг эргэн төлөх санхүүгийн тооцоо судалгаа, Монгол, Япон талууд ямар хувь хэмжээгээр хөрөнгө оруулснаар эргэн төлөлтийг барагдуулах талаар тооцооллыг нягталж, ЗТХЯ-ны ТНБД-д танилцуулсан.</p> <p>“УБ хотын ОУНОШБ-ын менежмент төсөл”-ийн төсөл хэрэгжүүлэх санал тавьсан Японы талын түншлэлийн төлөөлөлтэй ЗТХС 2017.08.15-ны өдөр уулзаж, шинэ нисэх буудлын барилга байгууламж, бэлтгэл ажлын явц болон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар санал солилцсон.</p> <p>Японы талын түншлэл, ЗТХЯ, ИНЕГ, Төсөл хэрэгжүүлэх нэгж, ИНЕГ-ын Ашиглалтын өмнөх захиргааны албаны төлөөллийг оролцуулсан хамтарсан уулзалтыг 2017.09.04-07-ны өдрүүдэд зохион байгуулж, “УБ хотын ОУНОШБ-ын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх санхүүгийн саналын төслийг хэлэлцэж, хувилбар тус бүрийн сул, давуу тал, тайлбар, судалгааг хийсэн. “УБ хотын ОУНОШБ-ын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээд байгуулах, хувь эзэмшлийг тогтоох талаар ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.</p> <p>Ажлын хэсэг менежментийн төслийг хэрэгжүүлэх санал тавьсан этгээдтэй уулзалт, хэлэлцээ хийж Монгол, Япон талуудын эзэмших хувь болон хөрөнгө оруулалтын эргэн төлөлтийг хэрхэн барагдуулах тооцооллыг хэлэлцсэн. Хэлэлцээний үр дүнд талууд 33 жилийн хугацаатайгаар Монголын тал 49, Японы тал 51 хувиар тус тус хувиар концесс эзэмших хувилбарыг сонгон ЗГХЭГ-т 2017.11.16-ны 01/5025 тоот албан бичгээр бичгээр хүргүүлж, ЗГ-ын 2017.11.29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, дэмжүүлсэн.</p> <p>МУЗГ-ын 2018.01.10-ны өдрийн хуралдаанаар шинэ нисэх буудлын менежмент төслийг хэрэгжүүлэх хамтарсан хуулийн этгээдтэй гэрээ байгуулахаар хийж байгаа хэлэлцээний явцын талаар танилцуулсан. Монголын талын 49%-г эзэмших Чингис хаан Олон улсын нисэх буудлын статусыг</p>	
--	--	--

	<p>өөрчлөн зохион байгуулах, менежмент хийх компанийн удирдлага зохион байгуулалттай холбоотой Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, Засгийн газрын 2018.05.02-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлсэн. ЗГ-аас холбогдох тооцоо судалгааг бэлтгэх, шинээр байгуулах компанийн нэрийг тодруулах чиглэл өгч материалыг буцаасан. Шаардлагатай тооцоо, мэдээллийг тодорхой болгож, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр дахин хүргүүлсэн. Засгийн газрын 2018.05.23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн ЗГ-ын 150 дугаар тогтоолоор баталсан.</p> <p>Тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЗТХС-ын 2018.06.26-ны өдрийн “Төрийн өмчийн төлөөлөгч томилж, удирдамж батлах тухай” 139 дүгээр тушаал, ТӨБЗГ-ын даргын 2018.06.27-ны өдрийн “Төрийн өмчийн төлөөлөгч томилж, удирдамж батлах тухай” а/203 дугаар тушаалаар Хувьцаа эзэмшигчдийн төлөөллийг хэрэгжүүлэх албан тушаалтнуудыг томилж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2018.06.28-ны өдөр хийж, компанийн дүрмийг баталсан. Компанийг 2018.07.08-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээг авсан. 2018.07.09-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн бүтэц, энэ оны төсвөө баталсан.</p> <p>ЕС-ын 2018.05.21-ний өдрийн 102 дугаар захирамжаар “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэхээр санал тавьсан этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, хавсралтаар Ажлын хэсгийн удирдамжийг батлуулсан.</p> <p>Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Японы консорциумтай 2018.05.24, 25-нд Концессын зүйлийн жагсаалт, 2018.06.08, 06.13-нд Концессын гэрээний санхүүгийн загвар, 2018.06.11- 2018.06.14 Концессын зүйлийн захиргаа удирдлагын нарийвчилсан хуваарилалт, Хувьцаа эзэмшигчдийн гэрээний талаар хэлэлцээг хийсэн.</p> <p>Мөн Монголын талын 49 хувийг эзэмшигч “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХК болон Японы консорциум хооронд хамтран ажиллах түншлэлийн гэрээг байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <p>Монголын талаас концессын гэрээний төслийг эхний байдлаар боловсруулан Японы консорциумд 2018.07.17-ны өдөр хүргүүлсэн. Японы консорциумаас уг концессын гэрээний төсөлтэй холбогдуулан 2018.07.10-ны өдөр албан бичгээр 6/Санхүүгийн загвар, газрын үйлчилгээ, аюулгүй байдал, газрын асуудал, гэрээний хэл, хувьцаа шилжүүлэх хязгаарлалт/ асуудлыг шийдвэрлүүлэхээр ирүүлснийг санхүүгийн болон хуулийн зөвлөхийн саналыг үндэслэн хянан үзэж холбогдох хариуг 2018.08.15-ны өдрийн 03/3872 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мөн 2018.08.08-ны өдөр Японы консорциумаас концессын гэрээний төсөлтэй холбогдуулан дахин 12/Нэр томъёоны тодорхойлолт, гэрээний талууд, талуудын хүлээх үүрэг, гэрээ хүчинтэй болох болон түүний урьдчилсан нөхцөл, концессын зүйлийг буцаан шилжүүлэх төлөвлөгөө, концессын төлбөр, концесс эзэмшигчийн гүйцэтгэлд хяналт дүгнэлт хийх, онцгой байдал, хувьцаа шилжүүлэх, эрх бүхий этгээдийн зөвшөөрөл, арилжааны боломжийг ашиглах, гэрээг хэрэгжүүлээгүй, зөрчсөн үеийн хохирлыг барагдуулах, маргаан шийдвэрлэх, гэрээний хэл/ асуудлыг шийдвэрлүүлэхээр ирүүлснийг хянан үзэж холбогдох хариуг 2018.09.11-ний өдрийн 03/4394 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>ЗГ-ын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын шатахуун хангамжийн байгууламжийн</p>	
--	---	--

		<p>менежмент төсөл"-ийг "ашиглах-шилжүүлэх" төрлөөр нэмэлтээр оруулах саналыг 2018.06.15-ны өдрийн 01/2842 тоот албан бичгээр ҮХГ-т хүргүүлсэн.</p> <p>Концессын гэрээний хэлэлцээрийг 2018.05.21-ний өдрөөс эхлүүлсэн бөгөөд Япон талаас ирүүлсэн гэрээний төсөлд саналаа тусган богино хугацаанд япон талтай хэлэлцээ хийж дуусгахаар ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна. Япон талаас 12 дугаар сард багтаан Концессын гэрээг байгуулах боломжгүй гэдгээ мэдэгдсэн тул МУ-ын ЕС-ын 12 дугаар сард Япон улсад хийх айлчлалын үеэр талууд хамтарсан мэдэгдэл хийгээд байна. Концессын гэрээг байгуулах ажлыг түргэвчлэх зорилгоор дэд ажлын хэсгүүд томилогдож, японы талтай хэлэлцээ хийж байна. Түншлэлийн гэрээ байгуулсан. Хувьцаа эзэмшигчдийн гэрээ, Концессын гэрээг 2019 оны 02 дугаар сард багтаан байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p> <p>2019 он: Ерөнхий сайдын 2018 оны 102, 2019 оны 43 дугаар захирамжаар тус тус шинэчлэн байгуулсан "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийг хэрэгжүүлэхээр санал тавьсан этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсэг концессын гэрээний хэлэлцээг хийж дууссан бөгөөд Концессын гэрээний төсөлд тохиролцсон голлох нөхцөлүүдийн талаар Засгийн газрын 2019.06.05-ны өдрийн хуралдаанд танилцуулан дэмжүүлсэн. Тус хуралдаанаар "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийг хэрэгжүүлэхээр санал тавьсан этгээдтэй байгуулах концессын гэрээний төслийг эцэслэн боловсруулж, гэрээ байгуулах эрх олгох тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Үндэсний хөгжлийн газарт даалгасан. "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийг хэрэгжүүлэх концессын гэрээний төсөл, ажлын хэсгийн дүгнэлт, Засгийн газрын тогтоолын төслийг Үндэсний хөгжлийн газарт 2019.06.18-ны өдрийн 01/3177 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үндэсний хөгжлийн газартай хамтран концесс олгох, хамтарсан компани байгуулах асуудлыг бэлтгэн Засгийн газрын 2019.06.28-ны хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, 259, 261 дүгээр тогтоолоор тус тус шийдвэрлүүлсэн. Концессын гэрээг 2019.07.05-ны өдөр байгуулсан. Уг гэрээг хүчин төгөлдөр болгоход шаардлагатай хамтарсан компанийн Хувьцаа эзэмшигчдийн гэрээ байгуулах, эхлэлтийн хөрөнгө оруулалтыг байршуулах, ажилтан шилжүүлэх гэрээ байгуулах "Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын үйл ажиллагааг эхлүүлэх нэгдсэн төлөвлөгөө" батлуулах зэрэг ажлуудыг хийснээр Концессын гэрээ 2019.09.01-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.</p>					
3	Улаанбаатар-Хөшигийн хөндий шинэ нисэх онгоцны буудлын хурдны зам төсөл	<p>Төслийн ажлын явц 86 хувь. Улаанбаатар хотыг шинэ нисэх онгоцны буудлыг холбосон хурдны авто замын барилгын ажлыг гүйцэтгэж байна.</p>	<p>Төслийн ажлын явц 95 хувь.</p> <p>Хурдны замын ажлыг гүйцэтгэнэ.</p>	<p>Гадаад зээл, тусламж /БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл/ Нийт 307,014.3</p> <p>2017 оны суурь үзүүлэлт 184,215.7</p>	<p>2018 он 81,760.4</p>	<p>2019 он 34,370.0</p> <p>Санхүүжсэн 90,332.0</p> <p>Санхүүжилтийн хувь 100</p>	100%
		<p>2018 он: Улаанбаатар-Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн 32.226 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын "Төмөр замын 4-р групп" компани шалгарч</p>					

		<p>2015.09.18-ны өдөр түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр нийт 140,335,893.00 ам.долларын барилгын ажил гүйцэтгэх гэрээг тус яамтай байгуулсан бөгөөд гэрээний дагуу 2018 онд авто замын барилгын ажлыг 90 хувьд хүргэж, 2019.04.18-ны өдөр ашиглалтад оруулна.</p> <p>Хяналтын зөвлөхөөр БНХАУ-ын “Гуанжоу Ванан Констракшн Супервишн” компани шалгарч 2016.05.18-ны өдөр 7,207,921.00 ам.долларын зөвлөхийн үйлчилгээний гэрээг мөн байгуулсан.</p> <p>2017 онд: Нийт ажлын явц 54.2%-тай. 7.8%-ийн хоцролттой.</p> <p>2018 онд: Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 368 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2018.02.06-ны өдрийн 45 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн.</p> <p>Батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2018.04.15-ны өдөр эхлүүлсэн бөгөөд талбай Талбай дээр хөрс хуулалт 100%, далангийн дүүргэлт 100%, хөлдөлтөөс хамгаалах үе 100%, буталсан суурийн ажил 100%, цементээр бэхжүүлсэн суурийн ажил 100%, харлуулсан дайрга 100%, хучилтын ажил 100%, гүүрийн ажил 100%, хиймэл байгууламжийн ажил 99.97%, туузан хашлага 90.6% тус тус хийгдээд байна. Нийт ажлын явц 96.19%-тай байна.</p> <p>2019 он: Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 60 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2019.02.20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2019.04.01-ний өдөр эхлүүлсэн. Нийт ажлын явц 100%-тай байна. Улсын комисс ажиллаж 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдөр улсын ашиглалтад оруулсан.</p>					
4	Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төсөл	<p>Төслийн ажлын явц 70 хувь. Логистикийн төвийн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Дэд бүтцийн ажлуудыг гүйцэтгэж дууссан.</p>	<p>Төслийн ажлын явц 100 хувь.</p> <p>Төслийг хэрэгжүүлж дуусна.</p>	<p>Гадаад зээл, тусламж /АХБ-ны хөнгөлөлттэй зээл/ 79,276.9</p> <p>2017 оны суурь үзүүлэлт 37,816.6</p> <p>Улсын төсөв Нийт 16,335.0</p> <p>2017 оны суурь үзүүлэлт 15,063.1</p>	<p>2018 он 33,899.6</p> <p>2018 он 1,271.9</p>	<p>2019 он 7,560.7</p> <p>Санхүүжсэн 11,480.2</p> <p>Санхүүжилтийн хувь 100</p> <p>-</p>	100%
<p>2018 он: Дорноговь аймгийн Замын-Үүд сумын нутаг дэвсгэрт хэрэгжиж буй “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх МОН 2719/0240 төсөл” нь АХБ-ны хөнгөлөлттэй зээл 40 сая ам.\$, АХБ-ны буцалтгүй тусламж 5 сая ам.\$, МУ-ын ЗГ-ын 26.64 сая ам.\$-ын санхүүжилтийн эх үүсвэртэй.</p>							

	<p>Барилга угсралтын ажлыг 2018.04.01-ний өдрөөс эхлүүлсэн. ЗГ-ын 2018 оны 72 дугаар тогтоолоор гадаадаас ажиллах хүч авахаар шийдвэр гарч тус логистикийн төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх 230 ажилтныг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн.</p> <p><u>АХБ-ны санхүүжилтээр:</u> Логистикийн төвийн барилга угсралт, төмөр замын дохиолол холбооны ажлыг “Хятадын төмөр замын 21-р товчоо групп” компани;</p> <p><u>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:</u> Авто зам, гүүрэн байгууламж, Хамгаалалтын хашааны, Логистикийн төвийг хангах эрчим хүчний шугам, дэд станцын, Логистикийн төвийг хангах цэвэр усны шугамын барилга угсралтын ажил, Логистикийн төвийн гадна холбоо интернетийн шилэн кабель суурилуулах ажил, Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ, Логистикийн төвийн зураг төсөлд магадлал хийх ажил, Цахилгаан хангамжийн зураг төсөл, төсөв боловсруулах ажил, 50 тн даацтай 2 вандан краны нийлүүлэх, угсралт, суурилуултын ажлуудыг “Ийстерн роуд” ХХК, “Ви Эйч энд Би” ХХК, “Катод гал” ХХК, “Хангилцаг” ХХК, “Лийд линк” ХХК, “Монвеком” ХХК, Барилгын хөгжлийн төв, “Баясалтөгс” ХХК, “Багануур Энерги” ХХК, “Хэнань Дафан Хүнд Машин механизм” компани тус тус гүйцэтгэж, 2018.12.04-ний өдрийн байдлаар ажил дууссан.</p> <p>Ложистикийн төвийн 50 тн даацтай 2 ширхэг иж бүрэн вандан краны тоног төхөөрөмжийн үйл ажиллагаанд холбогдох журмын дагуу МХЕГ-аас дүгнэлт гаргасан.</p> <p>Улсын комисс 2018.12.28-31-ний өдрүүдэд ажиллаж, дээрх ажлуудыг 18/432/02 дугаар актаар ашиглалтад хүлээн авсан.</p> <p>2019 он: Замын-Үүд логистикийн төвийг Замын-Үүд сумтай холбох 4,3 км авто замын барилгын ажлыг гүйцэтгүүлэхээр төслийн барилга, угсралтын ажлын гүйцэтгэгч “Хятадын төмөр замын 21 дүгээр товчоо групп” компанийг сонгон нэмэлтээр гэрээний өөрчлөлт №4-ийг 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр байгуулсан. Нийт төсөвт өртөг нь 1.4 сая ам.доллар бөгөөд гэрээт ажил хугацаандаа хийгдэж дууссан. Техникийн комисс 2019 оны 12 дугаар сарын 12-нд газар дээр нь ажилласан болно.</p> <p>Ложистикийн төвийн төслийн хүрээнд 1.2 км нарийн царигийн төмөр замын ажлыг 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр Гэрээний өөрчлөлт №6-ийн хүрээнд хийхээр болсны дагуу “Хятадын төмөр замын 21 дүгээр товчоо групп” компани хийж гүйцэтгэсэн. Нийт төсөвт өртөг нь 916.5 мянган ам.доллар бөгөөд Техникийн комисс 2019 оны 12 дугаар сарын 13-нд газар дээр нь ажилласан болно.</p>	
--	--	--

5	Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх 2 дахь шатны төсөл	<p>Төслийн ажлын явц 64 хувь.</p> <p>Ховд-Өлгий-Улаанбайшинт авто замын барилгын ажлыг 4 багц хэсгээр хэрэгжүүлж байна. Багц 1, 2 дуусч, багц 3 58%-тай, багц 4 эхлээгүй байна</p>	<p>Төслийн ажлын явц 70 хувь.</p> <p>Толбо сум-Хашаатын даваа чиглэлийн замын барилгын ажлыг дуусган, ашиглалтад оруулна.</p>	<p>Гадаад зээл, тусламж /АХБ-ны хөнгөлөлттэй зээл/ 312,500.0</p> <p>2017 оны суурь үзүүлэлт 80,597.1</p>	<p>2018 он 74,633.6</p> <p>Санхүүжсэн 2018 он 82,888.8</p>	<p>2019 он 57,494.4</p> <p>Санхүүжсэн 2019 он 27321.5</p>	100%
		<p>Улсын төсөв 46,460.0</p> <p>2017 оны суурь үзүүлэлт 26,931.9</p>	<p>2018 он 3,178.9</p>	<p>2019 он 5,000.0</p> <p>Санхүүжсэн 2019 он 5,000.0</p> <p>Санхүү-жилтийн хувь 100</p>			
<p>2018 он: “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд АХБ-ны 3129-МОН зээлийн хөрөнгөөр хэрэгжих Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 189.7 км авто замын барилгын ажлыг 4 багц хэсгээр зохион байгуулан хэрэгжүүлж байна. Зам барилгын ажлын гэрээг багц тус бүрээр 2015 оны 08 дугаар сард байгуулсан. Багц 1, 2, 3 хэсгийн барилгын ажил 2016 оны 05 дугаар сард эхэлсэн.</p> <p>Гадаадаас ажиллах хүч авах зөвшөөрлийг 2018.03.14-ний өдрийн ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлсэн. Барилгын ажлын нарийвчилсан график төлөвлөгөөг гарган батлуулан ажилласан. Зам барилгын ажлыг 04 дүгээр сард эхэлсэн.</p> <p>Зам барилгын ажлыг хэрэгжилтийг багц тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:</p> <p>Багц 1-1 хэсэг буюу Хашаатын даваа-Шурагийн гүүр чиглэлийн 50 км хатуу хучилттай авто замын барилгын дуусч 07/13/18 дугаар дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан.</p> <p>Багц 1-2 хэсэг буюу Шурагийн гүүр-Ховд чиглэлийн 53.9 км хатуу хучилттай авто замын барилгын ажил дуусч 07/13/18 дугаар дүгнэлтээр ашиглалтад хүлээн авсан.</p> <p>Багц 1-3 хэсэг буюу Толбо сум-Хашаатын даваа чиглэлийн 60 км хатуу хучилттай зам барилгын ажил 58%-тай, гэрээгээр 2019.09.30-ны өдөр ашиглалтад оруулна.</p> <p>Багц 4 хэсэг буюу Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажил эхлээгүй. Тус багцын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад гомдол гарч Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүхээс барилгын ажлыг түр түдгэлзүүлсэн бөгөөд 2016.10.26-нд шүүхийн шийдвэр гарсан. Энэхүү багцад гүйцэтгэгчээр шалгарсан Чайна Хуаши Энтерпрайзиз Лимитед Компанитай 2017.06.30-ны өдөр барилгын ажил гүйцэтгэх гэрээг цуцалсан. АХБ-наас дахин олон улсын өрсөлдөөнт сонгон шалгаруулалт зарлах тухай бичиг ирүүлсний дагуу 2017.09.06-ны өдөр олон улсын өрсөлдөөнт тендер зарласан боловч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас</p>							

		<p>шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай мэдэгдэл ирснээр тендерийг цуцалж шүүхийн шийдвэрийг биелүүлэхээр шийдвэрлэсэн. Шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажлын хүрээнд “Алтайн зам” ХХК-тай барилгын ажил гүйцэтгэх 105 дугаар гэрээг 2018.05.11-ний өдөр байгуулж АХБ-д хүргүүлсэн боловч АХБ тус багцыг санхүүжүүлэхээс татгалзсан.</p> <p>2019 он: Ховд-Өлгий чиглэлийн 60 км авто замын барилгын ажлын гүйцэтгэл тайлант хугацаанд гүйцэтгэл 100%-тай. 11 дүгээр сарын 16-ны өдөр улсын комисст хүлээлгэн өгсөн. Цагааннуур-Улаанбайшинт чиглэлийн 25.8 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтад 2016 онд гарсан шүүхийн шийдвэрийн улмаас АХБ-ны хөрөнгө оруулалтыг ашиглах боломжгүй болоод байсан ба АХБ-нд тус багц хэсгийг санхүүжүүлэх хүсэлтийг дахин 2019.03.28-ны өдөр тавьсан. АХБ-аастус багц хэсгийн гүйцэтгэгчийн тендерийг дахин зарлах зөвшөөрлийг 2019.07.30-ны өдөр ирүүлсэн. Тендерийн баримт бичгийн төсөлд АХБ-аас 2019.09.11-ний зөвшөөрөл авч тендерийг 09 сарын 12-ны өдөр зарласан. Тендерийг 10 сарын 25-нд нээсэн ба үнэлгээний тайланг АХБ-нд 11 дүгээр сарын 29-ний өдөр хүргүүлсэн. АХБ-аас үнэлгээний тайланд 2019.12.13-ны өдөр санал ирүүлсэн ба үнэлгээний тайланг саналд үндэслэн шинэчлэн боловсруулж байна.</p>					
6	Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км хатуу хучилттай авто зам төсөл	<p>Төслийн ажлын явц 80 хувь.</p> <p>Хөрс хуулалт 100%, далангийн дүүргэлт 100%, хөлдөлтөөс хамгаалах үе 100%, суурийн ажил 100%, гүүрийн ажил 100%, хиймэл байгууламжийн ажил 100%, хучилтын ажил 99.7% хийгдээд байна.</p>	<p>Төслийн ажлын явц 85 хувь.</p> <p>Заслын ажлуудыг хийж гүйцэтгэнэ.</p>	<p>Гадаад зээл, тусламж /БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл/ Нийт 110,482.0</p> <p>2017 оны суурь үзүүлэлт 33,587.6</p>	<p>2018 он 55,859.6</p>	<p>2019 он 5,527.0</p> <p>Санхүүжсэн 2019 он 15,358.3</p> <p>Санхүүжилтийн хувь 100</p>	100%
		<p>2018 он: Тус авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Шинжиан Бэйшин Роуд энд Бридж Групп” компани шалгарч 2016.04.15-ны өдөр нийт 42,198,856.39 ам.долларын ажил гүйцэтгэх гэрээг тус яамтай байгуулсан.</p> <p>Тус авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Шинжиан Бэйшин Роуд энд Бридж Групп” компани шалгарч 2016.04.15-ны өдөр нийт ажил гүйцэтгэх гэрээг тус яамтай байгуулсан. Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 138 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2018.02.06-ны өдрийн 45 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн.</p> <p>Батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2018.04.15-ны өдөр эхлүүлсэн бөгөөд талбай дээр хөрс хуулалт 100%, далангийн дүүргэлт 100%, хөлдөлтөөс хамгаалах үе 100%, суурийн ажил 100%, гүүрийн ажил 100%, хиймэл байгууламжийн ажил 100%, хучилтын ажил 99.7% тус тус хийгдээд байна. Нийт ажлын явц 99.98%-тай байна.</p>					

		2019 он: Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 35 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2019.02.20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2019.05.25-ны өдөр эхлүүлсэн. Нийт ажлын явц 100%-тай байна. Улсын комисс 2019.08.08-ны өдөр ажиллаж, улсын ашиглалтад хүлээн авч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээсэн					
7	Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто зам төсөл	Төслийн ажлын явц 70 хувь. Хөрс хуулалт 100%, далангийн дүүргэлт 100%, хөлдөлтөөс хамгаалах үе 100%, суурийн ажил 95.6%, гүүрийн ажил 98.6%, хиймэл байгууламжийн ажил 99.5%, хучилтын ажил 79.1% тус тус хийгдээд байна.	Төслийн ажлын явц 85 хувь. Барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ.	Гадаад зээл, тусламж /БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл/ Нийт 149,482.1 2017 оны суурь үзүүлэлт 45,264.6	2018 он 54,283.5	2019 он 29,182.4 Санхүүжсэн 2019 он 44,062.4 Санхүүжилтийн хувь 100	100%
		2018 он: Тус авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Шанхай Констракшн Групп” компани шалгарч 2016.04.15-ны өдөр нийт 56,785,696.10 ам.долларын ажил гүйцэтгэх гэрээг тус яамтай байгуулсанБатлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2018.04.01-ний өдөр эхлүүлсэн бөгөөд талбай дээр хөрс хуулалт 100%, далангийн дүүргэлт 100%, хөлдөлтөөс хамгаалах үе 100%, суурийн ажил 95.6%, гүүрийн ажил 98.6%, хиймэл байгууламжийн ажил 99.5%, хучилтын ажил 79.1% тус тус хийгдээд байна. Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар томилогдсон Ажлын хэсэг тухайн замын хучилт хийгдэж дууссан эхний хэсэг болох 103.5 км авто замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2018.11.19-ний өдөр нээсэн. Нийт ажлын явц 88.6%-тай байна.					
		2019 он: Барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 180 ажиллах хүчний асуудлыг ЗГ-ын 2019.02.20-ны өдрийн 78 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Батлагдсан график төлөвлөгөөний дагуу барилга угсралтын ажлыг 2019.04.01-ний өдөр эхлүүлж, суурийн болон хучилтын ажил бүрэн дууссан. Нийт ажлын явц 100%-тай байна. Улсын комисс 2019.08.06-ны өдөр ажиллаж, улсын ашиглалтад хүлээн авч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нээсэн.					
8	Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто зам. /Концессын эргэн төлөлт/	Төслийн ажлын явц 100 хувь. Төслөөр хийх ажил бүрэн дууссан. Хөрөнгө оруулалтын эргэн төлөлт хийгдэж дуусаагүй.	Эргэн төлөлт 90 хувь. Төсвөөс концессын эргэн төлөлт хийгдэнэ.	Улсын төсөв Нийт 147,854.2	2018 он 30,816.1	2019 он 28,017.9 Санхүүжсэн 2019 он ҮХГ-аас Санхүүжилтийн хувь	100%

		Алтай-Дарви чиглэлийн 98 км хатуу хучилттай авто замыг комиссын 2017.03.31-ний өдрийн 07/04/17 дугаар актаар баталгаажуулан улсын ашиглалтад оруулсан.					
9	Алтай-Дарви чиглэлийн 165 км хатуу хучилттай авто зам. /Концессын эргэн төлөлт/	Төслийн ажлын явц 100 хувь. Төслөөр хийх ажил бүрэн дууссан. Хөрөнгө оруулалтын эргэн төлөлт хийгдэж дуусаагүй.	Эргэн төлөлт 86 хувь. Төсвөөс концессын эргэн төлөлт хийгдэнэ.	Улсын төсөв Нийт 222,845.5 2017 оны суурь үзүүлэлт 78,825.3	2018 он 46,442.7	2019 он 42,225.4 Санхүүжсэн 2019 он ҮХГ-аас Санхүүжилтийн хувь	100%
		Тус чиглэлийн 165 км хатуу хучилттай авто замын барилгын ажил дуусч, комисс ажиллаж, 2017.12.08-ны өдрийн 07/16/17 дугаар дүгнэлт, хурлын тэмдэглэлээр баталгаажуулсан.					
10	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр зам төсөл	Төслийн ажлын явц 1 хувь. Гашуунсухайт-Ганцмодны боомтын төмөр замын холболтын цэгийг тодорхой болгоогүй тул төмөр замын ажлын зураг төслийг эцэслэн боловсруулах боломжгүй нөхцөл байдал үүсээд байна.	Төслийн ажлын явц 52 хувь. Барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.	Эх үүсвэр шийдвэрлэгдээгүй 950,688.3	2018 он -	2019 он 318,896.1 Санхүүжсэн 2019 он - Санхүүжилтийн хувь	100%
		2018 он: Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг үргэлжлүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016.09.13-ны өдрийн 01/653 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Ерөнхий сайдын 2016 оны 104 дүгээр захирамжаар байгуулагдсан УУХҮС-аар ахлуулсан ажлын хэсэг Тавантолгойн орд газар болон Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор гадаад дотоодын хөрөнгө оруулагч нартай хэлэлцээ хийсэн. Тус чиглэлийн төмөр замын барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийг БНХАУ-аас МУ-д хөнгөлөлттэй зээлээр олгох 1 (нэг) тэрбум ам.доллараас 400 сая ам.доллар олгохоор Засгийн газрын 2017 оны 222 дугаар тогтоолоор шийдвэрлүүлсэн. Үүнээс Засгийн газрын 2013 оны 82 дугаар тогтоолоор эхний ээлжинд шаардагдаж байгаа 200 сая ам.доллартай тэнцэх төгрөгийг Хөгжлийн банкаар дамжуулан Бондын санхүүжилтээс олгосон. Засгийн газрын 2017 оны 312 дугаар тогтоолоор дээрх 400 сая ам.доллар олгох тогтоолыг хүчингүй болгосон. Уг ажлын хүрээнд “Энержи ресурс рейл” ХХК-аас 74.6 сая ам.доллар, Хөгжлийн банкнаас 1.76 сая ам.долларын зээлээр тус тус санхүүжүүлж, өнөөгийн байдлаар нийт 279.2 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдсэн байдаг бөгөөд барилгын ажил зогссон. Уг төслийн ажил удаан зогссон тул					

	<p>дахин үргэлжилсэн тохиолдолд барилгын ажлын чанар байдлыг үнэлж байж гүйцэтгэх шаардлагатай ажлын тоо хэмжээ, зураг төслийг гаргах шаардлага үүссэн.</p> <p>Ерөнхий сайдын 2018 оны 04 дүгээр сард БНХАУ-д хийх айлчлалын бэлтгэл ажлыг хангах, тээврийн салбарт тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор ЗТХС Ж.Бат-Эрдэнэ 2018.01 дүгээр сард БНХАУ-д айлчилсан. Айлчлалын үеэр Хятадын Тээврийн яамтай Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийг шийдвэрлэх талаар хамтран ажиллах асуудлыг хэлэлцэж, Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замын холболтын цэгийг тогтоохоор тохиролцсон.</p> <p>Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг барьж байгуулахад нүүрсний төлбөр, нүүрсний урьдчилгаа төлбөр эсхүл нүүрсээр урт хугацаанд эргүүлэн төлөх нөхцөлөөр хэлэлцээ хийх УИХ-ын тогтоолын төслийг УУХҮЯ-аас боловсруулж, УИХ-ын 2018.06.29-ний өдрийн 73 дугаар тогтоол батлуулсан.</p> <p>Дээрх тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЗГ-ын 2018.08.08-ны өдрийн хуралдаанаар “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг эрчимжүүлэх тухай” 242 дугаар тогтоол батлуулсан, тус тогтоолоор тухайн чиглэлийн төмөр замын барилгын ажлыг үргэлжлүүлэхэд шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн барилгын ажлыг эхлүүлэх шийдвэр гарсан.</p> <p>“МТЗ” ТӨХК, “ЭТТ” ХК-ийн гүйцэтгэх захирлуудын хамтарсан 2018.08.24-ний өдрийн А/59/А/258 дугаар тушаалаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэгч “Тавантолгой төмөр зам” ХХК-ыг үүсгэн байгуулах ажлын хэсгийг байгуулсан.</p> <p>“МТЗ” ТӨХК, “ЭТТ” ХК-иудын хамтарсан хурлаар “Тавантолгой төмөр зам” ХХК-ийг үүсгэн байгуулж, компанийн дүрмийг баталсан. “МТЗ” ТӨХК-ийн ТУЗ-ийн хурлаар “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн ТУЗ-ийн 7 гишүүн, Гүйцэтгэх захирлыг томилж, 2018, 2019 оны төслийн менежментийн зардлын төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, компанийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог баталсан. Компанийг улсын бүртгэлийн газар бүртгүүлж, тамга тэмдэг авсан.</p> <p>Тус яамнаас хилийн холболтын цэг тогтоох тухай албан хүсэлтийг ГХЯ-нд 2 удаа хүргүүлээд байна. УИХ-ын 2014 оны 64 дүгээр тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг 1435 мм-ийн царигтай байхаар шийдвэрлэсэнээр төмөр замын ажлын зураг төсөл, техник-эдийн засгийн үндэслэлийг шинэчлэх шаардлага үүссэн. ТЭЗҮ шинэчлэн боловсруулах DBI компанийн үнийн санал болон “Жемер” ХХК болон “Грийн гетс” ХХК-аас ирүүлсэн БОНБНҮ-нд нэмэлт тодотгол хийхэд шаардлагдах үнийн саналуудыг авсан</p> <p>2019 он: Засгийн газрын 2019.07.24-ний өдрийн хуралдаанаар Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх санхүүжилт болон “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувь эзэмшлийг Засгийн газрын 304 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд барилгын ажил эхлүүлэх бэлтгэл ажлын Ерөнхий төлөвлөгөө гарган биелэлт 90%-тай байна. "Тавантолгой төмөр зам" ХХК нь захиалагч бөгөөд Ерөнхий гүйцэтгэгчээр "Бодь интернэшнл" ХХК-тай гэрээ байгуулсан. Тогтоолын хэрэгжилтийг хангаж Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн бичиг баримт, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг “Монголын төмөр зам” ТӨХК-аас “Тавантолгой төмөр зам” ХХК-д шилжүүлсэн. “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хувь эзэмшлийг тогтоон баталж ТУЗ-ийг шинэчлэх зэрэг ажлууд хийгдсэн. Цаашид төслийн барилгын</p>	
--	--	--

		ажлыг гүйцэтгэх ерөнхий гүйцэтгэгч сонгон шалгаруулах, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудлаар хуулийн хүрээнд шат дараатай гүйцэтгэнэ. Барилгын ажлын явц 56%-тай байна.					
11	Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто замын төсөл	<p>Бэлтгэл ажил.</p> <p>Концессын гэрээ байгуулах эрх олгосон тогтоол гарсан концесс эзэмшигч баталгаа гарган гэрээ байгуулагдахыг хүлээж байна.</p>	<p>Төслийн ажлын явц 30 хувь.</p> <p>Барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.</p>	<p>Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх Нийт 1,085,847.9</p> <p>2017 оны суурь үзүүлэлт -</p>	2018 он -	<p>2019 он 361,949.3</p> <p>Санхүүжсэн 2019 он ҮХГ-аас</p> <p>Санхүүжилтийн хувь</p>	40%
		<p>2018 он: ТЭЗҮ-ийг боловсруулах санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй. Тус төслийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг татах зорилгоор 2018.03.22-23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Монголын эрдэс баялаг-Уул уурхай-2018” хөрөнгө оруулалтын чуулга уулзалтад танилцуулсан. Засгийн газрын 2018.05.23-ны өдрийн 139 дүгээр тогтоолоор Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр зам барих төслийг "Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр хэрэгжүүлэхээр Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад "Шууд гэрээ байгуулах"-аар тусгасан. Мөн ЗГ-ын 2018.05.23-ны 153 дугаар тогтоолоор "Зүүнбаян төмөр зам" ХХК-тай Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замыг концессын "Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр барьж байгуулах хэлэлцээ хийж, гэрээний төслийг ЗГ-ын хуралдаанд танилцуулахыг Үндэсний хөгжлийн газарт даалгасан. Иймээс уг төмөр замтай зэрэгцүүлэн хүнд даацын цементбетон хучилттай 500 км авто зам барих нь эдийн засгийн хувьд ашиггүй гэж үзсэн. Харин эхний ээлжид Тавантолгойн нүүрсийг экспортлох шинэ гарц бий болгох, коксжих нүүрсээ Бугатын төмрийн үйлдвэр буюу эцсийн хэрэглэгчид шууд хүргэх боломжтой Тавантолгой-Ханги чиглэлийн хүнд даацын авто замын төслийг хэрэгжүүлэх нь улс орны эдийн засагт үр өгөөжөө өгөхөөс гадна замын барилгын ажилд зарцуулсан хөрөнгө оруулалтаа зам ашигласны хураамжаас нөхөх боломжтой. Оюутолгой болон бусад замын дагуух уурхайнууд уг замын төслийг дэмжиж байна гэдгээ илэрхийлээд байгаа.</p>					
		<p>2019 он: Засгийн газрын 2018.10.31-ний өдрийн 329 дүгээр тогтоолоор "Тал нутгийн хөгжлийн зам" ХХК-тай гэрээ байгуулах зөвшөөрлийг Үндэсний хөгжлийн газарт олгосний дагуу 2019.03.29-ны өдөр концессын гэрээ байгуулсан. Концесс эзэмшигчийн зүгээс гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөлүүдийг ханган, холбогдох материалыг Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн бөгөөд 2019 оны 12 дугаар сард эрх бүхий этгээдээс гэрээ хүчин төгөлдөр болсныг баталгаажуулсан.</p>					
12	Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 45.3 км төмөр замын төсөл	<p>Бэлтгэл ажил.</p> <p>Гэрээ нь шүүх байгууллагад шалгагдаж байгаагаас төмөр замын</p>	<p>Төслийн ажлын явц 40 хувь.</p> <p>Барилга угсралтын</p>	<p>Хувийн хэвшил Нийт 392,374.8</p> <p>2017 оны суурь үзүүлэлт -</p>	2018 он -	<p>2019 он 156,949.9</p> <p>Санхүүжсэн 2019 он –</p> <p>Санхүүжилтийн хувь -</p>	Үнэлэх боломгүй

		ажил зогсонги байдалтай байна.	ажлыг эхлүүлнэ.				
		<p>2018 он: Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын шугамын чигийг ЗГ-ын 2017 оны 126 дугаар тогтоолоор батлуулсан.</p> <p>БНХАУ-ын Зураг төслийн 3 дугаар хүрээлэн боловсруулсан Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын ТЭЗҮ, зураг төслийг “МАК” ХХК “Мөнгөн зөрлөг” ХХК-тай 2017 оны 05 дугаар сард гэрээ байгуулан шинэчлүүлсэн.</p> <p>Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын геологи, геодези, археологи, палентологийн судалгаанууд болон Техникийн зураг төслийг боловсруулсан.</p> <p>“МАК” ХХК, “Өсөх зоос” ХХК, “Өмнийн говийн элс” ХХК, “Чинхуа МАК Нарийнсухайт” ХХК нар хамтран “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-ийг байгуулсан.</p> <p>“Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай” ЗГ-ын 2018.08.01-ний өдрийн 232 тоот тогтоолоор “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-тай хамтарсан төрийн өмчийн тавин нэгээс доошгүй хувийн оролцоотой “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийг хууль тогтоомжийн дагуу байгуулахыг даалгасан.</p> <p>Тогтоолыг хэрэгжүүлэхээр “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-тай Төслийн хамтарсан “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийг байгуулахаар, компанийн хувьцаа эзэмшигчдийн гэрээний төслийг боловсруулсан. Уг боомтын төмөр замыг 2019 онд ашиглалтад оруулах зорилгоор ажлын нарийвчилсан төлөвлөгөө гарган Дэд сайдаар батлуулж, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>ЗГ-ын 2018.10.24-ний өдрийн хуралдаанаар тус чиглэлийн төмөр замын царигийн өргөний хэмжээг Улсын Их Хурлын 2014 оны “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 64 дүгээр тогтоолын 1 дэх заалтад нэмэлт оруулахыг дэмжиж, 44 дүгээр тэмдэглэл гарч УИХ-аар хэлэлцэхээр хүлээгдэж байна.</p> <p>Тус чиглэлийн төмөр замын барилгын ажлыг эхлүүлэх асуудал нь “Ар Ди Си Си” ХХК-ийн барьж байгуулсан Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн хатуу хучилттай авто замын “барих-ашиглах-шилжүүлэх” концессын гэрээний холбогдох зүйл, заалттай зөрчилдөн шүүх байгууллагад шалгагдаж байгаагаас төмөр замын ажил зогсонги байдалтай байна.</p>					
		<p>2019 он: Тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг бүрэн боловсруулж дууссан бөгөөд царигийн өргөний хэмжээг УИХ-аар тогтоосны дараа барилгын ажлыг эхлүүлнэ. Цариг шийдвэрлэгдээгүй үед барилгын ажил эхлүүлэх боломжгүй тухай хөрөнгө оруулагч талаас албан ёсоор мэдэгдээд байна. УИХ-ын 2019 оны Хаврын чуулганаар 2014 оны 64 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцүүлэх явцад тус төслийн ТЭЗҮ, тооцоо судалгааг дахин нягтлах гэсэн шалтгаанаар Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 21 дүгээр тэмдэглэл гарч буцаан татсан. Засгийн газрын 2018 оны 232 дугаар тогтоолоор Шивээхүрэн-Сэхэ боомт хооронд 13 км төмөр зам барих тухай шийдвэр гарсан хэдий ч тухайн төмөр замын царигийн өргөний хэмжээ тодорхойгүйгээс барилгын ажил эхлүүлэх боломжгүй байна.</p>					
13	Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км	Төслийн ажлын явц 0 хувь. Уралдаант шалгаруулалтад шаардлага хангасан	Төслийн ажлын явц 20 хувь.	Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх	2018 он -	2019 он 44,000.0 Санхүүжсэн 2019 он -	Үнэлэх боломжгүй

	цемент бетон хучилттай их даацын авто зам	төслийн санал ирээгүй тул концессын тухай хуулийн дагуу шууд гэрээ байгуулах нөхцөл бүрдсэн.	Төслийг хэрэгжүүлэгчтэй гэрээ байгуулан, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэнэ.	Нийт 220,000.0 2017 оны суурь үзүүлэлт -		Санхүүжилтийн хувь	
<p>2018 он: Концессын “зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэхээр ЗГ-ын 2017.06.14-ний өдрийн 166 дугаар тогтоолоор Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад нэмж тусгасан. Уг тогтоолын дагуу ҮХГ-аас 2017.08.16-ны өдөр “Баруун-Урт-Бичигт чиглэлийн 272 км цемент бетон хучилттай их даацын авто зам төсөл”-ийн концесс олгох 2 үе шаттай уралдаант шалгаруулалтыг зарласан. Урьдчилсан шалгаруулалтад оролцох саналыг 2017.10.16-ны өдрийн 11.00 цаг хүртэл хүлээн авсан бөгөөд тус төсөлд 1 оролцогч санал ирүүлсэн бөгөөд комисс уг оролцогчийн саналыг үнэлж, дараагийн үе шат болох уралдаант шалгаруулалтад оруулахаар шийдвэрлэсэн.</p> <p>Комиссоос уралдаант шалгаруулалтын баримт бичиг боловсруулан тус оролцогчид 2018.01.16-ны өдөр баримт бичгийг олгож эхэлсэн бөгөөд төслийн саналыг 2018.04.19-ний өдрийн 11.00 цагт нээсэн боловч нэг ч санал ирээгүй болно.</p>							
<p>2019 он: Уралдаант шалгаруулалтад шаардлага хангасан төслийн санал ирээгүй тул концессын тухай хуулийн дагуу шууд гэрээ байгуулах нөхцөл бүрдсэн. Үндэсний хөгжлийн газраас концесс эзэмшигчийг сонгон шалгаруулах шууд гэрээний урилгыг 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хүлээн авахаар 2019.08.30-ны өдөр цахим хуудсандаа байршуулсан боловч санал ирээгүй. Иймд тус төслийг цаашид концессоор хэрэгжүүлэхэд дахин төслийн санал ирүүлэх магадлал бага байгаа тул хөрөнгө оруулалтын өөр хэлбэрээр хэрэгжүүлэх боломжийг судлаж үзэхийг хүссэн 01/3163 дугаартай албан тоотыг Үндэсний хөгжлийн газраас тус яаманд ирүүлсэн.</p>							
14	Тяньжин тээвэр логистикийн төв байгуулах төсөл	Төслийн ажлын явц 4 хувь. Хамтын ажиллагааны ерөнхий хэлэлцээрийг байгуулсан. Ерөнхий хэлэлцээрийн дагуу тусгай зориулалтын хамтарсан компани байгуулахаар ажиллаж байна.	Төслийн ажлын явц 30 хувь. Хөрөнгийг шийдүүлж, байршуулна. Төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын хамтарсан компани байгуулна.	Хувийн хэвшил Нийт 124,362.0 2017 оны суурь үзүүлэлт -	2018 он –	2019 он 37,308.6 Санхүүжсэн 2019 он – Санхүүжилтийн хувь	70%

	<p>2018 он: МУ-ын Зам, тээврийн хөгжлийн яам болон БНХАУ-ын Тяньжин хотын Ардын Засгийн газар хооронд Тяньжин хотын Бинхай шинэ дүүрэгт хоёр талын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх тухай санамж бичгийг 2018 оны 05 дугаар сард албан шугамаар шинэчлэн байгуулсан.</p> <p>2018 оны 06 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд Тяньжин хотын Ардын Засгийн газрын Гадаад харилцааны газрын дарга Ли Сү Ян тэргүүтэй, Тяньжин порт групп, Дунзян бүсийн төлөөлөгчид Монгол Улсад айлчлан Зам, тээврийн хөгжлийн Дэд сайд болон “МТЗ” ТӨХК-ийн Гүйцэтгэх захиралтай уулзалт зохион байгуулсан. Уулзалтын хүрээнд талууд төслийн хэрэгжилт, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн бөгөөд Монголын талын хөрөнгө оруулагчийг ойрын хугацаанд сонгон шалгаруулан, БНХАУ-д хамтарсан компани байгуулахаар зорьж ажиллахаар санал нэгдсэн. Хамтын ажиллагааны ерөнхий хэлэлцээрийг 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдөр БНХАУ-ын улс төрийн товчооны гишүүн, Тяньжин хотын намын нарийн бичгийн дарга Ли Хунг Жун айлчлах үеэр Монголын талаас ЗТХЯ, “МТЗ” ТӨХК, БНХАУ-ын талаас Тяньжин хотын Ардын засгийн газар, Тяньжин Порт Группийн хооронд байгуулсан. Ерөнхий хэлэлцээрийн дагуу төслийн зориулалттай компани байгуулахаар ажиллаж байна.</p> <p>2019 он: 1. Монгол-Хятадын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны хүрээнд БНХАУ-ын хууль тогтоомжийн дагуу Тяньжин хотод шинээр байгуулагдах “Хятад-Монголын Олон Улсын Логистикийн бүс” ХХК-д хөрөнгө оруулж 49 хувийн хувьцааг эзэмших, хамтран ажиллах эрхийг “Монголиан порт групп” ХХК-д олгох асуудлыг 2019.04.17-ны өдөр Монгол улсын Засгийн газрын хуралдаанд оруулан хэлэлцүүлж, тэмдэглэл гарсан.</p> <p>2. БНХАУ-ын Тяньжин хотын Дунзяны чөлөөт худалдааны боомт бүсэд тээвэр, логистикийн үйл ажиллагаа эрхлэх зоиулалттай Монголын талын 49 хувь, Хятадын талын 51 хувийн хөрөнгө оруулалттай хамтарсан компани байгуулах ЗГ-ын 164 дүгээр тогтоол 2019.04.23-ны өдөр гарсан.</p> <p>3. Энэхүү Засгийн газрын тогтоолын дагуу 05-р сарын 26-ны өдөр “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Цэнгэл нь “Тяньжин порт (групп)” ТӨХК-ийн охин компани болох “Тяньжин портын эдийн засаг, техник технологийн хамтын ажиллагаа” ХХК-тай “Хятад-Монголын Олон Улсын Логистикийн Бүс” ХХК-г байгуулах хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан. Мөн 05-р сарын 27-ны өдөр “Хятад-Монголын Олон Улсын Логистикийн Бүс” ХХК-ийн ТУЗ-ийн анхдугаар хурал хуралдаж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон Гүйцэтгэх захирал, Дэд захирлыг томилсон.</p> <p>4. 2019.06.27-ны өдөр “Хятад-Монголын Олон Улсын Логистикийн Бүс” ХХК-ийг БНХАУ-ын (Тяньжин) чөлөөт худалдаа туршилтын бүс зах зээлийн хяналт, зохицуулалтын газар-т бүртгүүлэн компанийн гэрчилгээг авсан.</p> <p>5. 2019 оны 07 дугаар сард “Монголиан порт групп” ХХК-аас Монголын талын хөрөнгө оруулалтын эхний хэсгийг “Хятад-Монголын Олон Улсын Логистикийн Бүс” ХХК-д байршуулсан.</p> <p>6. “Монголиан порт групп” ХХК-аас Монголын талын хөрөнгө оруулалтын дараагийн хэсгийг “Хятад-Монголын Олон Улсын Логистикийн Бүс” ХХК-д байршуулахаар яаравчлан ажиллаж байна.</p> <p>7. 2018 оны 12 дугаар сард Тяньжин хотын Олон Улсын инженерингийн зөвлөх компаниас Тяньжин тээвэр логистикийн төв төслийн ТЭЗҮ-ийн саналын төслийг “Монголын төмөр зам” ТӨХК-д ирүүлсэн бөгөөд ТЭЗҮ-шинэчлэсэнтэй холбогдуулан 01 дүгээр сарын 18-ны өдөр МТЗ ТӨХК болон МУУХМ ХХК-ийн хамтарсан Ажлын хэсэг байгуулагдсан. Шинэчилсэн ТЭЗҮ-ийг хамтарсан Ажлын хэсэг авч</p>	
--	--	--

		<p>хэлэлцэн ТЭЗҮ-д өгөх саналыг боловсруулан 2019.02.25-ны өдөр “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Цэнгэл болон холбогдох төлөөлөгчид Тяньжин хотноо айлчлах үеэр Тяньжин порт групп-ын удирдлагуудад албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>8. Мөн 2019 оны 03 дугаар сарын 04-ний өдөр Тяньжин хотын Олон Улсын инженерингийн зөвлөх компанийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, ТЭЗҮ-ийн дэлгэрэнгүй танилцуулгыг хийж, Монголын талаас хэд хэдэн тодруулга асуулт тавьсны зэрэгцээ уул уурхайн бүтээгдэхүүнийг Хятадын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөхөд байгаль орчны нөлөөлөлд тавигдах шаардлага, төслийн санхүүгийн загварчлалын талаарх мэдээллийг Монголын талд гаргаж өгөхийг хүссэн.</p> <p>9. Хамтарсан Ажлын хэсгийн тавьсан асуудлын дагуу одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа хөнгөлөлттэй бодлогын тарифыг тусгаж ТЭЗҮ-ийн санхүүгийн тооцоололд өөрчлөлт оруулахаар болсон.</p>					
15	Авто замын дагуу үйлчилгээний төв байгуулах төсөл	-	Төслийн ажлын явц 20 хувь.	Барих-Өмчлөх-Ашиглах 106,000.0 2017 оны суурь үзүүлэлт -	2018 он -	2019 он 20,000.0 Санхүүжсэн 2019 он 10,000.0 Хувийн хэвшил Санхүүжилтийн хувь 50	100%
		<p>2018 он: ЗТХ-ийн сайд, аймгийн Засаг даргатай зам, тээврийн салбарт 2018 онд хамтран ажиллах гэрээнд автотээврийн салбарт шаардлагатай байгаа авто замын дагуух үйлчилгээний цогцолборын барилга байгууламжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барих-өмчлөх-ашиглах сонирхолтой аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж ажиллах заалтыг тусгасан. Дараах аймаг, сумдад авто замын дагуух үйлчилгээний цогцолбор барьж ашиглалтад оруулсан. Үүнд: 1. Төв аймгийн Лүн сумын нутаг дэвсгэрт улсын чанартай авто замын дагуу “Урьхан-2” үйлчилгээний цогцолбор; 2. Баян-Чандмань сумын нутаг дэвсгэрт Аглагийн хийд рүү эргэдэг уулзварын үйлчилгээний цогцолборыг тус тус барьсан. Улаанбаатар хот, Ховд, Завхан, Дорнод зэрэг аймгуудад шаардлагатай автобуудал, авто замын дагуух үйлчилгээний цогцолборын барилга байгууламжийг орон нутгийн концессын зүйлийн жагсаалтад оруулж, сонирхогч аж ахуйн нэгжээр барих-өмчлөх-ашиглах төрлөөр хэрэгжүүлэхээр аймаг, нийслэлийн ИТХТ-ийн шийдвэр гаргуулж, хэрэгжилтийг хангах талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллаж байна.</p>					
		<p>2019 он: 2019 онд Зам, тээврийн хөгжлийн сайд, 21 аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээнд олон улсын болон улсын чанартай авто замын дагуу төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд авто замын дагуух үйлчилгээний барилга байгууламжийг барьж байгуулах заалтыг тусгуулсан. Баянхонгор аймгийн Баянхонгор суманд “Номгон оюу” ХХК, Булган аймгийн Рашаант</p>					

		сумын нутаг дэвсгэр “Элсэн тасархай”-т “Сод хан трэвел” ХХК, Багануур дүүрэг "Минимакс", Ховд аймгийн Дарви сумын нутаг дэвсгэрт "Бумбат цоцолбор" зэрэг улсын чанартай авто зам дагуу хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд авто замын дагуух үйлчилгээний барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулж үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.					
16	Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн 67 км авто зам барих төсөл	<p>Төслийн ажлын явц 10 хувь.</p> <p>2018 онд тухайн төслийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардлын хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй тул зам барилгын ажлыг эхлүүлэх боломжгүй болсон. Тухайн төслийн тусгайлсан зээлийн хэлэлцээрийг байгуулсан.</p>	<p>Төслийн ажлын явц 35 хувь.</p> <p>Барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.</p>	<p>Гадаад зээл, тусламж /БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл/ Нийт 52,850.6</p> <p>2017 оны суурь үзүүлэлт -</p>	<p>2018 он –</p>	<p>2019 он 1,000.0</p> <p>Санхүүжсэн 2019 он 26,759.6</p> <p>Санхүүжилтийн хувь</p>	100%
		<p>2018 он: Захиалагч 2016 оны 12 дугаар сард тус авто замын барилгын ажлын гэрээг дүгнэн хөрөнгийн эх үүсвэр өөрчлөгдөж байгаатай холбогдуулан гэрээг дуусгавар болгосон. Барилгын ажил 60%-тай байна.</p> <p>БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замын барилгын үлдэгдэл ажлыг санхүүжүүлэхээр БНХАУ-ын Эксим банктай тохиролцож, ЗГ-ын 2017 оны 132 дугаар тогтоолоор БНХАУ-ын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Тус яамны зүгээс уг авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах хязгаарлагдмал тендерийг Сангийн яам болон Монгол Улсад суугаа БНХАУ-ын Элчин сайдын ирүүлсэн албан бичгийн дагуу 3 аж ахуйн нэгжийн дунд зохион байгуулсан бөгөөд гүйцэтгэгчээр “Чайна Коммуникэйшн Констракшн” ХХК-тай шалгарч 2018.03.12-ны өдөр нийт 18.9 сая ам.долларын өртөгтэй гэрээг байгуулснаар тухайн төсөлд Засгийн газрын 2017 оны 132 дугаар тогтоолоор батлагдсан хөрөнгөөс 5.1 сая ам.долларыг хэмнэсэн.</p> <p>Хяналтын зөвлөх үйлчилгээний зардалд шаардагдах нэмэлт хөрөнгийг тус зээлийн хөрөнгийн хэмнэлтээс шийдвэрлэх саналыг Хятадын талд тавьж шийдвэрлүүлэх асуудлыг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэж, ЗГ-ын 2018.05.16-ны өдрийн 133 дугаар тогтоолоор баталсан.</p> <p>БНХАУ-аас МУ-д суугаа Элчин сайдын яамнаас санал болгосон “Гуанжоу Ванан Констракшн Супервишн” ХХК-тай хэлэлцээр хийж, зөвлөх үйлчилгээний гэрээг 2018.07.03-ны өдөр байгуулан 2018.07.04-ний өдрийн 03/3221 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн боловч Хятадын Эксим банкнаас зөвлөхийг санхүүжилтийг олгох боломжгүй талаар албан бичгийг Сангийн яам болон тус яаманд ирүүлсэн.</p> <p>Сангийн яамнаас 2018.08.20-ны өдрийн албан бичгээр Эксим банкнаас зөвлөхийн зардлыг санхүүжүүлэх боломжгүй болсон тул тухайн зөвлөхийн зардлыг шийдвэрлэх холбогдох арга хэмжээг</p>					

		<p>авч хэрэгжүүлэх талаар мэдэгдсэн. Үүнтэй холбогдуулан тус яамнаас чиглэлийн авто замын хяналтын зөвлөх үйлчилгээний зардал 2,265,596,740,2 төгрөгийг 2019 оны Төсвийн тухай хуульд тусгуулж, шийдвэрлүүлэхээр Сангийн яаманд 2018.08.27-ны өдөр албан бичиг хүргүүлсэн. 2018 онд тухайн төслийн хяналтын зөвлөх үйлчилгээний зардлын хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй тул зам барилгын ажлыг эхлүүлэх боломжгүй болсон.</p> <p>Тухайн төслийн тусгайлсан зээлийн хэлэлцээрийг 2018 оны 08 сард байгуулсан.</p> <p>2019 он: Тус авто замын барилгын ажилд өдөр тутмын техник, технологийн хяналт тавих зөвлөхийн үйлчилгээний зардлыг 2019 оны Улсын төсвийн урсгал зардалд тусгаж шийдвэрлэсэнтэй холбогдуулан зөвлөх үйлчилгээ үзүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулахаар худалдан авах ажиллагааг зохион байгуулж, зөвлөхөөр шалгарсан "Мөнхөд ашдын зам"ХХК-тай 2019.06.05-ны өдөр гэрээ байгуулаад байна.</p> <p>Тус яамны зүгээс 2019.05.23-ны өдөр улаан шугамыг гүйцэтгэгч компанид хүлээлгэн өгсөн бөгөөд 2019.06.07-ны өдөр авто зам, замын байгууламжийн барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг гүйцэтгэгч компанид өгсөн.</p> <p>Талбай дээр 133 машин механик, тоног төхөөрөмж, 290 хүн ажиллаж байна. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 229 дүгээр тушаалаар авто замын барилгын ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан Завхан аймгийн Алдархаан, Идэр, Яруу сумдын нутаг дэвсгэр дэх Загастайн давааны дээрх чиглэлийн 67 км авто замыг 2019.07.13-наас 10.15-ны өдрийг хүртэлх хугацаанд түр хааж, барилгын ажлыг гүйцэтгэж байна. 2019 оны жилийн эцсийн байдлаар нийт ажлын гүйцэтгэл өссөн дүнгээр 65 хувьтай байна.</p> <p>Гүйцэтгэгч компанитай байгуулсан гэрээний дагуу барилга угсралтын ажлыг 2020.10.30-ны өдөр ашиглалтад оруулна.</p>					
17	Бүс нутгийн автозамыг хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл /үндсэн ба нэмэлт санхүүжилт/	<p>Бэлтгэл ажил.</p> <p>Зээлийн гэрээг байгуулсан. Зураг төслийг боловсруулж дууссан.</p>	<p>Төслийн ажлын явц 15 хувь.</p> <p>Барилга угсралтын ажлыг эхлүүлнэ.</p>	<p>Гадаад зээл, тусламж /АХБ-ны хөнгөлөлттэй зээл/ Нийт 315,840.0</p> <p>2017 оны суурь үзүүлэлт -</p>	<p>2018 он</p> <p>–</p>	<p>2019 он 44,487.0</p> <p>Санхүүжсэн 2019 он 52,770.6</p> <p>Санхүүжилтийн хувь 100</p>	70%
		<p>2018 он: Төслийн хэрэгжүүлэх 60 сая ам.долларын МОН-3679 зээлийн гэрээг Монгол улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банк хооронд 2018 оны 7 дугаар сарын 24-ны өдөр байгуулсан. Төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажын хүрээнд төслийн замын зураг төслийг боловсруулж дуусан. Зам барилгын ажлын зөвлөхийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.</p> <p>2019 он: 2019 онд төслийн хүрээнд дараах ажил үйлчилгээг хэрэгжүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажлын ажлын зураг төслийг 2019 оны 03 дугаар сард эцэслэн боловсруулж дуусгасан. Зам барилгын ажлын гүйцэтгэгийг сонгон шалгаруулах олон улсын тендерийг 5 багц хэсгээр 2019 оны 03 					

		<p>сарын 21-нд зарлаж, 05 дугаар сарын 02-ны өдөр нээсэн. Шалгарсан гүйцэтгэгч компаниудтай 2019 оны 06 сарын 12-14-ны өдрүүдэд байгуулсан. Зам барилгын ажлыг 2019 оны 06 сарын 17-ны өдөр эхлүүлсэн. Тайлант хугацаанд нийт барилгын ажлыг гүйцэтгэл 33.2%-тай байна.</p> <ul style="list-style-type: none"> ▪ Зам барилгын ажилд техник, технологийн хяналт тавих зөвлөхийн сонгон шалгаруулалтын ажлыг 2019 оны 01 сараас 05 дугаар сарын хугацаанд зохион байгуулж, шалгарсан зөвлөх компанитай 2019 оны 06 сарын 05-ны өдөр байгуулан, зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлж байна. ▪ Төслийн 2 дахь шатны МОН-3786 зээлийн хэлэлцээрийг 2019 оны 03 дугаар сарын 13-14-ны өдрүүдэд зохион байгуулсан. Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг 2019 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр УИХ-аар соёрхон баталсан ба Зээлийн гэрээг Монгол Улсын Засгийн газар болон АХБ хооронд 2019 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан. ▪ Дархан-Албанбулаг чиглэлийн аюулгүй байдлыг сайжруулахад чиглэгдсэн засвар арчлалтын ажлыг зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлсэн. <p>Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 58 км авто замын их засвар ажлын зураг төслийг 2019 оны 08 дугаар сард боловсруулж дууссан. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийн баримт бичгийн төслийг боловсруулж АХБ-аас зөвшөөрөл авахаар хүргүүлсэн.</p>					
18	Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км авто зам	<p>Төслийн ажлын явц 100 хувь. Төслийн ажил дуусаж, зам ашиглалтад орсон хэдий ч улсын төсвийн санхүүжилт саатсан тул төслийг бүрэн хаагаагүй.</p>	<p>Төслийн ажлын явц 100 хувь. Үлдэгдэл санхүүжилт бүрэн шийдвэрлүүлж, төслийг бүрэн дуусгана.</p>	<p>Улсын төсөв Нийт 80,122.9</p> <p>2017 оны суурь үзүүлэлт 79,439.4</p>	<p>2018 он -</p>	<p>2019 он 683.5 Санхүүжсэн 2019 он - Санхүүжилтийн хувь</p>	Үнэлэх боломжгүй
<p>2017 онд тус авто замыг Улсын байнгын ашиглалтад оруулсан. Үлдэгдэл санхүүжилт 2019 оны төсөвт тусгагдсан бөгөөд баталгаат засварын хугацаанд улсын комиссоос өгөгдсөн үүрэг даалгаврыг биелүүлэн төсөвт тусгагдсан эцсийн гүйцэтгэлээ авах байсан боловч гүйцэтгэгч ажлаа хийж гүйцэтгээгүй. Тухайн ажлыг хийж гүйцэтгэсний дараа улсын төсөвт тусгуулан санхүүжих боломжтой.</p>							
1.2 ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛҮҮД							
Зам, тээврийн хөгжлийн сайд							
19	Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн	-	<p>Төслийн ажлын явц 20 хувь</p>	<p>Эх үүсвэр шийдвэрлэгдээгүй 2,258,276.6 Хувийн</p>	<p>2018 он - -</p>	<p>2019 он 1,235,462.6 Санхүүжсэн -</p>	70%

	төмөр замын төсөл			хэвшил 750,000.0 2017 оны суурь үзүүлэлт -		2019 он 750,000.0 Санхүүжсэн 199,300.0 Санхүүжилтийн хувь 30	
<p>2019 он: Ерөний сайдын 2019.05.01-ний өдрийн 53-р захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн дэд даргаар ажилласан. Нийт 8 удаагийн хурал хийж 39 асуудалыг шийдвэрлэж ажилласан байна. 2019.08.14-ний өдрийн 106 дугаар захирамжаар ажлын хэсгийн даргаар томилсон бөгөөд нийт 6 удаагийн хурал хийж 52 асуудлыг шийдвэрлэсэн байна. Мөн барилгын ажлын явцтай газар дээр нь 5 удаа очиж танилцсан. Барилгын ажлын далангийн гүйцэтгэл 23%-тай явагдаж байна. Зүүнбаян талаас эхний 50 км-т 3 гүүр, 52ш хоолойн ажлыг эхлүүлээд байна. 4.5 км дээд бүтцийн угсралтын ажлыг хийж гүйцэтгээд байна. Барилгын ажил 10%-тай.</p>							
20	Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.6 км авто замын шинэчлэлийн төсөл	Бэлтгэл ажил. Зураг төслийг бэлэн болгож, АХБ-аас зөвшөөрөл авсан.	Төслийн ажлын явц 30 хувь. ТЭЗУС, ТЭЗҮ хийнэ.	Гадаад зээл, тусламж /АХБ, ЕСБХБ-ны хөнгөлөлттэй зээл/ 455,000.0 2017 оны суурь үзүүлэлт -	2018 он -	2019 он 151,666.0 Санхүүжсэн 2019 он 360,000.0 Санхүүжилтийн хувь 100	100%
<p>2019 он: Тус чиглэлийн авто замын шинэчлэлтийн ажилд техник технологийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулж 2019.06.05-ны өдөр гэрээ байгуулсан. Шинэчлэлтийн ажлыг 5 багцад хуваан гүйцэтгэгчийг сонгон гэрээ байгуулж барилгын ажлыг эхлүүлсэн. Барилга угсралтын ажил 33%-тай байна.</p>							
21	Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай 60 км авто зам	-	Төслийн ажлын явц 10 хувь. Барилгын ажлыг эхлүүлнэ.	Улсын төсөв Нийт 48,000.0 2017 оны суурь үзүүлэлт -	2018 он -	2019 он 5,000.0 Санхүүжсэн 2019 он 5,000.0 /Ирүүлсэн гүйцэтгэл 6.1 тэрбум төгрөг/ Санхүүжилтийн хувь 100	100%
<p>2019 он: ТНБД-ын 2019 оны 40 дүгээр тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийг 2019.02.27-ны өдөр зарласан бөгөөд 2019.04.01-ний өдөр нээсэн.</p>							

		<p>Үнэлгээний хороо тендерийг үнэлж, шаардлагад нийцсэн нэг ч оролцогч оролцоогүй тул хуулийн дагуу хүчингүй болгосон.</p> <p>Иймд ТШ-ыг 2019.06.03-ны өдөр дахин зарласан бөгөөд 2019.07.03-ны өдөр нээсэн. "Тотал Инж" ХХК-д гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн боловч Сангийн яаманд "Арц суварга" ХХК гомдол гаргасан бөгөөд үндэслэлгүй гэсэн шийдвэр ирсэн тул "Тотал инж" ХХК, "Рингроуд" ХХК-ийн түншлэлтэй 2019.08.05-нд гэрээ байгуулж, барилгын ажлыг эхлүүлсэн. БУА 13.5%-тай байна.</p>					
22	Даланжаргал ан-Бор-Өндөр чиглэлийн хатуу хучилттай 50 км авто зам	-	<p>Төслийн ажлын явц 10 хувь. Барилгын ажлыг эхлүүлнэ.</p>	<p>Улсын төсөв Нийт 49,368.2</p> <p>2017 оны суурь үзүүлэлт -</p>	2018 он -	<p>2019 он 5,000.0</p> <p>Санхүүжсэн 2019 он 5,000.0 /Ирүүлсэн гүйцэтгэл 9.2 тэрбум төгрөг/ Санхүүжилтийн хувь 100</p>	100%
<p>2019: ТНБД-ын 2019 оны 41 дүгээр тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдсан. Тендерийг 2019.02.22-ны өдөр зарласан бөгөөд 2019.03.25-ний өдөр нээсэн. Тендерийг үнэлж хамгийн сайн үнэлэгдсэн оролцогч "Билэгт зам" ХХК-тай 2019.04.19 өдөр гэрээ байгуулж, барилгын ажлыг эхлүүлсэн. БУА 20%-тай хийгдэж байна.</p>							
23	Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр, 63 км авто замын ажил	-	<p>Төслийн ажлын явц 10 хувь.</p> <p>Барилгын ажлыг эхлүүлнэ.</p>	<p>Улсын төсөв Нийт 69,000.0</p> <p>2017 оны суурь үзүүлэлт -</p>		<p>2019 он 5,000.0</p> <p>Санхүүж-эн 2019 он 5,000.0 Санхүүжилтийн хувь 100</p>	70%
<p>2019 он: Зам, тээврийн хөгжлийн Сайдын 2019 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" 9 дүгээр тушаалаар Архангай аймгийн Засаг даргын Тамгын газарт эрх шилжсэн. 2019 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу 2 дугаар улиралд тендер шалгаруулалтыг зохион байгуулсан боловч шаардлага хангасан тендер ирүүлээгүй тул шууд гэрээний санал хүргүүлэн 2019.11.11-ны өдөр "Хурдны зам" ХХК-тай гэрээ байгуулсан байна.</p>							
24	Улсын чанартай авто зам, гүүрийн засвар, арчлалт	-	<p>Төслийн ажлын явц 100 хувь.</p> <p>Зам хариуцагч төрийн өмчит 20, хувийн</p>	<p>Улсын төсөв 30,000.0</p>	-	<p>2019 он 30,000.0</p> <p>Санхүүжсэн 29,968.1</p>	100%

/улсын хэмжээнд/		хэвшлийн 8, нийт 28 компанитай гэрээ байгуулан ажиллаж байна.			Санхүүжилтийн хувь 96.7	
	<p>2019 он: Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Зам, тээврийн хөгжлийн сайдын багцын хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтын XIV.1.2.2-д заасныг үндэслэн олон улсын болон улсын чанартай авто зам, гүүрийн засвар, арчлалтын ажлын 2019соны төлөвлөгөөг зам хариуцагч 32 компаниин хариуцдаг авто замыг чиглэл тус бүрээр, өвлийн улиралд ажиллах шуурхай ажлын хэсгүүдийн байршил, ажиллах хүч, машин, механизм, гүүрийн хамгаалагч-засварчин ажиллуулах гүүрүүдийн байршил, цалингийн зардлыг тус бүрд нь боловсруулан тооцож Зам, Тээврийн хөгжлийн Сайдын 2018 оны 12-р сарын 21-ний өдрийн 288тоот тушаалаар батлуулсан.</p> <p>2019 онд хийгдэх засвар арчлалтын ажлын тоо хэмжээг газар дээр нь явж тогтоож график төлөвлөгөөг баталсан.</p> <p>Өдөр тутмын хяналтыг “ЗТХТ” ТӨҮГ-аас гүйцэтгэж батлагдсан график төлөвлөгөөний дагуу замын засвар, арчлалтын ажил 100% хийгдэж дууссан.</p>					
НИЙТ						91.4%